



ДАРХАН –УУЛ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

Хамтарсан багуудын
үйл ажиллагаанд хийсэн хяналт-
шинжилгээ, үнэлгээ



Эрх зүйн үндэслэл

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны А/236 дугаар тушаалыг үндэслэн, Аймгийн хэмжээний хамтарсан багуудын үйл ажиллагаанд хяналт –шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг 2019 оны 06 дугаар сарын 04-нөөс 27-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Хамтарсан багуудын дараах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд:

1. Хамтарсан багийн зохион байгуулалт
2. Гишүүдийн чиг үүргийн хэрэгжилт
3. Хүүхэд хамгаалын үйлчилгээ
4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгчид үзүүлэх үйлчилгээ
5. Үйл ажиллагааны санхүүжилт



Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 23 хамтарсан багаас 11 багийн үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хамтарсан багийн 67 гишүүний үүргийн хэрэгжилтийг оноогоор үнэлж, дүгнэлт гаргаж ажиллаа. Үүнд:

1. Дархан сумын 1, 2, 4, 5, 7, 12, 15 дугаар баг
2. Шарын гол сумын Хайрхан, Санжинт баг
3. Хонгор сумын хамтарсан баг
4. Орхон сумын хамтарсан баг



Нэг. Хамтарсан багийн зохион байгуулалт

Аймгийн хэмжээнд хамтарсан багийг Засаг даргын захирамжаар 30%, ИТХ-ын тогтоолоор 70% байгуулан, үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна.



Хамтарсан багууд жилийн ажлын төлөвлөгөөгөө багийн ахлагчаараа баталгаажуулсан, төлөвлөгөө боловсруулахад оролцож хийх ажлын чиглэлээр саналаа өгч ажилласан байна.

Хамтарсан багийн хурлын дундаж ирц 70.3%-тайгаар хуралдаж, хуралд оролцсон гишүүдийн 56.7 хувь нь хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж хурлын тэмдэглэлээ файл үүсгэж хадгалж ажилладаг сайн талууд байна.



Хоёр. Гишүүдийн чиг үүргийн хэрэгжилт

1. Дархан сумын 5, 7 дугаар баг, Шарын гол сумын Санжинт, Хайрхан, Хонгор, Орхон сумын багууд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар дуудлага мэдээллийг хүлээн авч цаг алдалгүй ажиллаж, ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгжийн дэмжлэг сайтай, багийн гишүүд хуваарийн дагуу багийн нутаг дэвсгэртээ эргүүл хийдэг, хүчирхийллийг илрүүлэхэд санаачилгатай ажиллаж байна.
2. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан, Түр хамгаалах байранд хүлээлгэж өгч, аюулгүй байдлыг хамгаалалтад хамруулсан байна.



Дархан сумын 5-р баг –ЕБС-н
ахлах ангийн 100 хүүхдийн
дунд "Хүүхдүүдээ сонсоё"
анхдугаар зөвлөгөөн



Дархан сумын 5 багаас иргэдийнхээ оролцоог хангах санал санаачилга гаргаж, жил бүр “Амгалан өрх” өдөрлөг, “Хүүхдээ сонсоё” зөвлөгөөнийг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй архины хамааралтай иргэнийг архинаас гаргах зан үйлийг өөрчлөх сургалтад хамруулан ажлын байранд зуучлах, өрхийн орлоготой, гэр олгож, газрынх нь асуудлыг шийдвэрлэн ажилласан.



Гурав. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭНД
41 ХҮҮХЭД

1-4 ТӨРЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНД

26 УДАА
ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛСЭН.

Үйлчилгээг төрийн
байгууллага, ТББ-
иудыг оролцуулан
шуурхай
шийдвэрлэсэн байна.



Дөрөв. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгчид үзүүлэх үйлчилгээ

ГЭР БҮЛИЙН
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ
ДУУДЛАГА 19

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХАМГААЛАЛТ
10

ХОЛБОН ЗУУЧЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ
4

СЭТГЭЛ ЗҮЙН
ҮЙЛЧИЛГЭЭ
19



1. Дуудлага мэдээллийн дагуу хохирогчийн эрх ашгийг хамгаалж, хуульд заасан үйлчилгээг хүргэсэн.
2. Хүчирхийлэл үйлдэгчийг дуудаж ирүүлэн хууль тогтоомжийн дагуу сануулах арга хэмжээ авч ажилласан.



Дархан сумын 2, 5, 7 баг,
Шарын гол сумын
Санжинт, Хайрхан баг,
Хонгор сумын хамтарсан
багууд хохирогч,
хүчирхийлэл үйлдэгчийн
Зан үйлд нөлөөлөх
сургалтад хамруулж
ажилласан байна.



Тав. Үйл ажиллагааны санхүүжилт

Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг боловсруулж саналаа аймаг сумын ИТХ-д хүргүүлж шийдвэрлүүлэх талаар санал санаачилга гаргаж ажиллаагүй.



Хамтарсан багийн үйл ажиллагааны санхүүжилт, төсвийн зарцуулалт

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23-р зүйл:
23.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөв тусган санхүүжүүлнэ.



Ерөнхий дүгнэлт

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын 23 багаас 11 багийг сонгон авч үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж ажиллахад дараах нийтлэг асуудлууд байна. Үүнд:

1.Хамтарсан багийн гишүүд төлөвлөгөө боловсруулахад 55.5% нь оролцож, тайлан боловсруулахад гишүүд нь оролцдоггүй, улирал болон хагас жилээр үйл ажиллагааны тайлан, тоон мэдээг нэгтгэж холбогдох дээд шатны байгууллагуудад хүргэж тайлагнаж ажилладаггүй байна.

2.Шуурхай хурал зарласан тохиолдолд нийт гишүүдийн 70.3% нь оролцдог ч нөхцөл байдлын үнэлгээ хийх, тухайн гэр бүлийн асуудлыг шийдвэрлэхэд багийн засаг дарга, нарийн бичгийн дарга, хэсгийн байцаагч нар ихэнх тохиолдолд оролцдог.

3.Хамтарсан багийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг дутуу зурдаг



4. Сар бүр тогтмол хурал зохион байгуулж багийн хурлаар хэлэлцэх асуудлаа тодорхойлдоггүй.

5. Эрсдэлд нөхцөлд амьдарч буй хүүхэд, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авсан хүүхэд, гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхдийн талаар дэлгэрэнгүй судалгаа байхгүй, судалгаанд суурилсан үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна.

6. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын дагуу хамтарсан багууд яаралтай арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч, гишүүдийн ажлын ачааллаас болж гэр бүлд тавих хяналт дутмаг, эргэх холбоо байхгүй, үйлчилгээ үзүүлсэн үр дүнгээ тооцдоггүй аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулж ажилладаггүй байна.

7. Хамтарсан багаар шаардлагатай үйлчилгээг үзүүлэхэд хөрөнгө санхүүгийн асуудлыг өөрсдийн боломж, аж ахуйн нэгжийн хандив тусламжаар шийдвэрлэж ирсэн байна.



8. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, улс, орон нутгийн төсөвт тусгах саналаа хүргүүлж санал санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

9. Гишүүдээс хамгааллын үйлчилгээ үзүүлсэн тохиолдол бүрийн мэдээ баримт, үйлчилгээний зардлыг багийн ахлагч болон хамтарсан багийн нарийн бичгийн даргад тайлагнадаггүй.

10.Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулалт хангалтгүй, нууцыг хадгалах гэрээг кейс бүрт хийдэггүй, ярилцлагын тэмдэглэл хөтөлдөггүй, баталгаажуулалт дутмаг, үйлчилгээний үр дүнг тооцдоггүй, эргэх холбоо сул.

11.Хууль тогтоомжийг иргэд орон нийтэд таниулах талаар багууд хангалтгүй ажиллаж байна.



Зөвлөмж

1. Хамтарсан багийн ахлагч гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангах, ажил үүргийг жигд хуваарилах, хурлын товыг гаргаж багийн гишүүдийн оролцоо хангах талаар санал санаачилгатай ажиллах.
2. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, гишүүдэд мэдээллээр хангаж, хурлын бэлтгэл ажлыг хангах, гишүүдээс чиг үүрийнх нь дагуу тайлан мэдээ авах хугацаанд нь дээд шатны байгууллагад тайлагнаж хэвших.
3. Багийн жилийн ажлын төлөвлөгөө, санхүүжилт, багийн ахлагчид танилцуулж шийдвэрлэхэд анхаарч ажиллах.
4. Урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг сайжруулах, хамтарсан багийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах.
5. Үйлчилгээний маягтуудыг журмын дагуу бүрэн хөтлөх аргад суралцах.
6. Хамтарсан багийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн илрүүлэлтийг сайжруулах.



Цаашид анхаарах асуудал:

- Хууль, тогтоомж, журмуудын хэрэгжилтийг хангах.
- Салбаруудын уялдаа холбоог сайжруулах.
- Мэргэжил, аргазүйн дэмжлэгийг ажлын байран дээр нь үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх.
- Хамтарсан багуудад нийгмийн ажлын, сэтгэл зүйн болон эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг байгуулагуудын хаяг, байршил, холбогдох утас, үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүртээмжтэй байлгах.
- Хамтарсан багаас хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хамтарсан багийн гишүүдийг урьдчилан сэргийлэх үйлчилгээний аргазүй, ур чадварт сургах чиглэлээр чадавхжуулах.
- Хамтарсан багийн гишүүдийг тогтвор суурьшилтай ажилдуулах асуудал дээр анхаарах.



ХАМТАРСАН БАГ КЕЙС ШЙИДВЭРЛЭЛТЭД АНХААРАХ АСУУДЛУУД:





**Хүүхэд, багачуудын сайн сайхны
төлөө хийсэн үйлс болгон дэлгэрч
Үр шимийг нь хүүхэд бүхэн хүртэж байх
болтугай.**

